



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 36

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 163,500,000.00 (нэг зуун жаран гурван сая таван зуун мянган) төгрөгийн балансын үнэ, 100,753,485.60 (нэг зуун сая долоон зуун тавин гурван мянга дөрвөн зуун наян таван төгрөг жаран мөнгө) төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг Гаалийн ерөнхий газрын харьяа Сайншанд дахь Гаалийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт, Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт, Гаалийн ерөнхий газрын харьяа Сайншанд дахь Гаалийн газрын дарга О.Цээнрэгзэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Захиргаа, хууль зүйн хэлтсийн дарга А.Ариунболд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлтцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
2019 ОНЫ 04 ДУЗЭР-САРЫН 30НЫ ӨДРИЙН
136 дугаар Тогтолцыг хавсралт
ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БУРТГЭЛТЭЙ, ГААЛИЙН ЕРӨНХИЙ ТАЗРЫН
ХАРЬЯА САЙНШАНД ДАХЬ ГААЛИЙН ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖУУЛЭХ ХӨРӨНГӨ
6098169 ▶ 1116362383

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БУРТГЭЛТЭЙ, ГААЛИЙН ЕРӨНХИЙ ТАЗРЫН
ХАРЬЯА САЙНШАНД ДАХЬ ГААЛИЙН ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖУУЛЭХ ХӨРӨНГӨ

Д/д	Хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуимтлагдсан элзэдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Ниссан патрол, 10-26 УНҮ (арал-јиlapu6270030046)	2018	ш	1	163,500,000.00	163,500,000.00	62,746,514.40	100,753,485.60
	Нийт дун					163,500,000.00	62,746,514.40	100,753,485.60